



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Монголбанкинд компьютер нийлүүлэх,**

Тендер шалгаруулалтын дугаар: **Б -2019/2**

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос компьютер нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ.

**Багц – 1: Зөөврийн компьютер**

**Багц – 2: Ширээний компьютер**

Тендерт оролцогч нь аль ч багцад оролцох боломжтой. Тендер шалгаруулалтыг багц тус бүрээр хийнэ.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрд лээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: **Багц тус бүрт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Багц тус бүрт санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жил: **2017 оны Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, 2018 оны Санхүүгийн тайлан.**

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгох үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгааг багц тус бүрт ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг **2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 10 цаг 40 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,

Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,

Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471